



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ХӨВСГӨЛ АЙМГИЙН УЛААН-УУЛ
СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН
ХОРООНЫ ДАРГА
Г.ЭРДЭНЭБАЯР ТАНАА

2024.07.30 № 01/590
танай _____-ны № _____-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын Ардчилсан намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын Ардчилсан намын хорооны Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд

оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага болон холбогдох бусад хууль, тогтоомжид тус тус нийцсэн байна.

Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын Ардчилсан намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөр (4 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын Ардчилсан намын хороонд

Хувийг: Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын Сонгуулийн хороонд

Хавсралт . 4. хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР



**Хөвсгөл аймаг Улаан-Уул сумын
Ардчилсан намын хороо**

**Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын Ардчилсан намын 2024 оны орон нутгийн
сонгуулийн мөрийн хөтөлбөр**

Зорилго:

Монгол Улсын тусгаар тогтнол, Үндэсний эрх ашиг, Үндсэн хуульт ардчиллаа хамгаалан бэхжүүлж, хувь хүний эрх чөлөө, хуулийн засаглал, чөлөөт зах зээл, иргэний нийгмийн зарчимд суурилсан тогтвортой хөгжлийн төлөөх нам. Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын хөгжил цэцэглэлтийн төлөө нийгэм, эрүүл мэнд, байгаль орчны салбарт шинэчлэл хийж хариуцлагатай иргэний нийгмийг төлөвшүүлнэ. Мөн "Алсын хараа 2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Хөвсгөл аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг тус тус удирдлага болгон хэрэгжүүлэн ажиллах зорилготой.



[Handwritten signature]

0000000001

Хөдөлмөр эрхлэлтийн бодлого:

- 1.1 Хөдөлмөрт бэлтгэх сургалт
- 1.2 Хөдөлмөр эрхлэлтийн сургалт
- 1.3 Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сургалт хөтөлбөр
- 1.4 Хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөр, сургалт
- 1.5 Хөгжлийн бэрхшээлтэй болон ажил олоход хүндрэлтэй иргэнийг ажлын байраар хангасан ажил олгогчийг дэмжих хөтөлбөр, сургалтууд

2. Нийгмийн халамжийн бодлого:


- 2.1 Сумын иргэдийг жил бүр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулна.
- 2.2 Ахмад настнуудыг хөдөлмөр эрхлэх боломжоор хангах талаар гаргасан санал, санаачилгыг дэмжинэ.
- 2.3 Гэр бүл, хүүхэд, залуусын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх орчин бий болгоход зориулсан цэцэрлэгт хүрээлэн, тоглоомын талбайн тохижилтыг сайжруулж, спорт заал барих ажлын зураг төсөв, тооцоо судалгааг хийж холбогдох байгууллагад уламжлан, шийдвэрлүүлнэ.
- 2.4 Хүүхэд, залуусыг урлаг, спортоор тууштай хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарч, бүх талаар дэмжинэ.
- 2.5 Өрх толгойлсон эх, эцэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлт, өрхийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр гаргасан санал, санаачилгыг дэмжин, хамтарч ажиллана.
- 2.6 Иргэдийн тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, гэмт хэргийг бууруулах зорилгоор гудамж талбайн гэрэлтүүлэгт анхаарч, гэр хорооллуудыг нарны эрчим хүчээр цэнэглэгддэг гэрэлтүүлэгтэй болгох, хяналтын камертай болгох ажлыг шат дараалан шийдвэрлэнэ.
- 2.7 Гэр бүлийн хүчирхийлэл, ахуйн хүрээнд гардаг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, "хөршийн хамгаалалт" иргэдэд суурилсан амгалан тайван байдлын тогтолцоо бүрдүүлнэ.

3. Хөдөө аж ахуйн чиглэлээр:

- 3.1 Хөдөөгийн малчдад "малчин" мэргэжил эзэмшүүлж, өрхийн аж ахуйгаа хөтөлж явуулах боломжоор хангана.
- 3.2 Хоршоо, нөхөрлөл бүлэг багаар ажиллах малчдыг тусгайлсан хөтөлбөрөөр дэмжиж ажиллана.
- 3.3 Малын гоц халдвар, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга, үйлчилгээний төсвийг нэмэгдүүлнэ.
- 3.4 Мах, махан бүтээгдэхүүний үнийг тогтвортой байлгах зорилгоор махны нийлүүлэлтийн шинэ тогтолцоог бүрдүүлнэ.

4. Засаглалын бодлого

- 4.1 Ёс зүйтэй, хүнд сурталгүй, соёлтой, зөрэг хандлагыг төрийн албанд төлөвшүүлнэ.



A handwritten signature in black ink, consisting of a series of loops and strokes, is written over the bottom right corner of the page.

0000000002

4.2 Төрийн албан хаагчид танил талдаа төсөл хөтөлбөр, сум хөгжүүлэх сангийн зээлд хамрагдахад давуу эрх олгоход байдал болон намын харьяаллаар иргэдэд ялгавартай ханддаг байдлыг зогсооно.

4.3 Төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэлтэй иргэд цахимаар болон биечлэн танилцах нөхцөл боломж бүрдүүлнэ.

4.4 Сум хороодын цагдаагийн байгууллагын ажлын уялдаа холбоог сайжруулна.

5. Авто зам, тээвэр

5.1 Авто замын хөгжлийн мастер төлөвлөгөөг боловсруулж холбогдох байгууллагад уламжилж бусад сууринтай холбох ажлыг дэс дараатай хийнэ.

5.2 Зайлшгүй шаардлагатай гүүр, сайжруулсан зам барих асуудлыг иргэдийн оролцоотойгоор шийдвэрлүүлнэ.

5.3 Тээврийн салбарт ачаа эргэлтийг нэмэгдүүлж ачаа тээврийн сүлжээ бий болгоно.

5.4 Авто вокзал байгуулах, зорчих тээврийн нэгдсэн сүлжээг бий болгож цагийн хуваарьт оруулна.

6. Биеийн тамир, спортын салбарын хөгжлийн бодлого:

6.1 Сум, багын хэмжээнд нийтийн биеийн тамирын арга хэмжээг өргөн хүрээтэй зохион байгуулж, иргэдийн бие бялдрыг хөгжүүлэх материаллаг баазыг бэхжүүлж, иргэдийн эрүүл мэндийг сайжруулж, шилдэг тамирчдыг бэлтгэхэд дэмжлэг үзүүлнэ.

6.2 Нийтийн биеийн тамирыг хүн амын өдөр тутмын хэрэглээ болгох, өдөрт өөртөө боломжит хугацааг зарцуулах, дундаж наслалтыг нэмэгдүүлэх чиглэлээр спортын гадаа талбай болон ногоон орчныг бүрдүүлэх ажлыг дэмжинэ.

6.3 Сумын спорт заалыг стандартад нийцсэн үйл ажиллагаатай болгон тэмцээн уралдааныг зохион байгуулна.

6.4 Дугуйн болон гүйлтийн зам шинээр барьж өсвөр үе, хүүхэд залуучуудыг биеийн тамир, спортоор тогтмол хичээллэх нөхцөлийг бүрдүүлнэ.

6.5 Спорт заалыг техник, тоног төхөөрөмж болон бөхийн дэвжээгээр хангана.

6.6 Спортын холбоо, клубуудыг дэмжиж ажиллана.

7. Байгаль орчин

7.1 Байгалийн нөөцийн хамгаалалт, нөхөн сэргээлтэд хамтын менежментийн зарчмыг тууштай нэвтрүүлэх замаар ой, ан, байгалийн ургамлын нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ажиглахад иргэдийн оролцоог сайжруулна.


7.2 Жил бүр байгаль хамгаалах иргэдийн нөхөрлөл, идэвхтэн байгаль хамгаалагч, байгаль орчны мэргэжлийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулна.

7.3 Ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар түгээмэл, нэн ховор, ховор ургамлын тархац нутаг нөөцийн хэмжээг тогтоож, зохистой хэрэглээ бий болгоно.

1720000001-0070605

0000000003

- 7.4 Ан, агнуурын ач холбогдолтой ан амьтдын тархац нутаг, нөөц, сүргийн бүтэц, агнуурын бүс нутгийг тогтоох чиглэлээр агнуур зохион байгуулалт хийх
- 7.5 Иргэдийн экологийн боловсрол хүмүүжлийг дээшлүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлнэ.
- 7.6 Ногоон хөгжлийн үндсийг бүрдүүлэн, "ногоон соёл иргэншил" үзэл баримтлал, хөтөлбөрийг боловсруулж, загваруудыг бий болгоно.
- 7.7 Сум дахь иргэний байгууллага, иргэдийн нөхөрлөлтэй байгаль хамгааллын чиглэлээр хамтран ажиллах тогтолцоог шинэ шатанд гаргана.



A handwritten signature in blue ink, located at the bottom right of the page.

000000000004